

БИЗНЕСИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Нэг. Ерөнхий мэдээлэл

1.1. Монгол Улсын бизнесийн, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчны өнөөгийн нөхцөл байдал

Монгол Улсын Үндсэн хуульд “эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх”-ийг эрхэм зорилго болгон тунхагласан. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна”, 2 дахь хэсэгт “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, 3 дахь хэсэгт “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно” хэмээн тус тус заасан.

Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж заасан бөгөөд 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөнд “.... хувийн аж ахуй эрхлэх эрхтэй” хэмээн суурь эдийн засгийн эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулж өгсөн.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “...эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно” гэж, “бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх” гэсэн зорилтыг дэвшүүлсэн.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Эдийн засгийн бодлого” гэсэн 3 дугаар бүлэгт “Зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулан, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, олон тулгуурт, хүртээмжтэй, экспортын баримжаатай эдийн засгийг бэхжүүлнэ” гэж, тус бүлгийн 3.1-д заасан “Эдийн засгийн эрх чөлөө” хэсгийн 3.2.2.1-д “Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хуулиудыг шинэчилж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, бизнес эрхлэгчийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” гэж, 3.2.2.3-т “Шинэ аж ахуйн нэгжүүдийн зах зээлд нэвтрэхэд тулгардаг саад хоригийг арилгаж, гарааны компаниудын бизнесийг дэмжих экосистемийг бүрдүүлэх, зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, монополын эсрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” гэж, 3.2.2.4-т “Төрийн байгууллагуудаас зөвшөөрөл олгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, зөвшөөрлийн нэгдсэн платформыг эхлүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсад бизнес эрхлэхтэй холбоотой харилцааг шууд болон шууд бус хэлбэрээр зохицуулсан 360 гаруй хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаа ч бизнесийн үйл ажиллагааны явцад төр болон бизнес эрхлэгчдийн хооронд баримтлах зарчмууд тухайлбал, хуулиар хориглосноос бусад тохиолдолд бизнесийн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх, бизнесийн тогтвортой байдлыг хангах, төр, хувийн аж

ахуй нэгжүүдтэй өрсөлдөхгүй байх, төрийн оролцоог бууруулах зэрэг суурь зарчмуудыг тусгасан нэгдсэн хууль одоогоор байхгүй байна.

1.2. Хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлага

Бизнес, худалдаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь эдийн засгийн бүх салбар, үйл ажиллагааг хамарсан өргөн хүрээний харилцаа бөгөөд тэдгээрийг зохицуулж буй хууль тогтоомж, төрийн байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа хангалтгүй, салбар хоорондын зохицуулалт сул байгаа нь бизнес эрхлэх орчинд тодорхой бус байдал, давхардал, хүндрэл үүсгэж байна. Иймд, Монгол Улсад бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд төр ба бизнес эрхлэгч хооронд баримтлах үндсэн баримт бичиг буюу суурь зарчмыг тогтоосон нэгдсэн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Дэлхийн өв уламжлалын сангаас “Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс”-ийг эрх зүйт ёс, Засгийн газрын оролцоо, зохицуулалтын үр ашигтай байдал, нээлттэй зах зээл гэсэн нийт 4 бүлэг 12 шалгуур үзүүлэлтийг ашиглан тооцдог. 2025 онд Монгол Улс нийт дүнгээрээ 184 улсаас 63.9 оноотойгоор 69 дүгээр байранд эрэмбэлэгдсэн байна.

Бүлэг	Шалгуур үзүүлэлт/дэд хүчин зүйлс	Оноо	Онооны ангилал	Байр
Эрх зүйт ёс	Өмчийн эрх	49.2	хаалттай	92/184
	Шүүхийн үр ашиг	54.9	хязгаарлагдмал	73/184
	Төрийн зарчимт байдал	35.8	хаалттай	114/184
Засгийн газрын оролцоо	Татварын ачаалал	83.7	чөлөөтэй	65/184
	Засгийн газрын зарлага	64.6	дунд	117/184
	Төсвийн сахилга бат	96.1	чөлөөтэй	33/184
Зохицуулалтын үр ашигтай байдал	Бизнесийн эрх чөлөө	68.4	дунд	76/184
	Хөдөлмөрлөх эрх чөлөө	68.2	дунд	17/184
	Мөнгөний эрх чөлөө	72.1	нээлттэй	116/184
Нээлттэй зах зээл	Худалдааны эрх чөлөө	74.4	нээлттэй	82/184
	Хөрөнгө оруулагчдад ээлтэй байдал	50.0	хязгаарлагдмал	114/184
	Санхүүгийн зах зээлийн нээлттэй байдал	50.0	хязгаарлагдмал	97/184


Шалгуур үзүүлэлтүүдийг задалж үзвэл, “бизнесийн эрх чөлөө” үзүүлэлтээр 76-т эрэмбэлэгдэж “дунд”, “хөрөнгө оруулагчдад ээлтэй байдал” үзүүлэлтээр 114-т эрэмбэлэгдэж “хязгаарлагдмал”, “өмчийн эрх”-ийн үзүүлэлтээр 92-т эрэмбэлэгдэж “хаалттай”, “төрийн зарчимт байдал” үзүүлэлтээр 114-т эрэмбэлэгдэж “хаалттай” гэж үнэлэгдсэн байна. Үүнээс үзэхэд Монгол Улсад хувийн өмч хөрөнгийн баталгааг сайжруулах, бизнесийн эрх чөлөөг нэмэгдүүлэх, төрийн зарчимт байдал болон

хөрөнгө оруулагчдад ээлтэй байдлыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Монгол Улсын эдийн засагт 1994 оноос хойш уул уурхайн салбарын эзлэх хувь тэлж, уул уурхайн бус салбар, тэр дундаа хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь агшжээ. Тухайлбал, уул уурхайн салбарын нийт ДНБ-д эзлэх жин өнгөрсөн 30 жилд 10 хувиас (1994) 26 хувь болж (2025) өссөн бол хөдөө аж ахуйн салбарын жин 27 хувиас 9 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын жин 17 хувиас 7 хувь болж тус тус буурсан байна. Энэ нь эдийн засаг төрөлжихгүй, зөвхөн нэг салбарт харьцангуй ихээр төвлөрч байна.

Эдийн засгийн өсөлт 2025 оны эцсийн байдлаар 6.8 хувьд хүрч, 2026 оны эцэст 5.8 орчим хувь байх төсөөлөлтэй байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал 2025 онд 3.8 тэрбум ам.доллар болж, өмнөх оноос 8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Монгол Улсын 2026 оны төсвийн 75 хувийг урсгал зардал бүрдүүлж байгаа бөгөөд цаашид боловсрол, эрүүл мэндийн салбарын цалингийн зардал өсөх хандлагатай байгаа нь төсвийн ачааллыг улам нэмэгдүүлэхээр байна. Төсвийн хөрөнгө оруулалтаар шинэ төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал байгаа өнөөгийн нөхцөлд гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эдийн засгаа идэвхжүүлэх шаардлагатай байна.

График 1. ГШХО-ын орох урсгал



Гадаад талаас сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудад бодлогын болон бүтцийн өөрчлөлтүүд явагдаж, худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэл өөрчлөгдөж байгаа энэ цаг үед дэлхийн улс төр, эдийн засгийн нөхцөл байдалд тодорхой бус байдал эрчимтэй нэмэгдэж байна. Худалдааны дайны цар хүрээ улам бүр тэлж болзошгүй байгаа нь дэлхийн эдийн засгийн идэвхжилийг хязгаарлах, инфляцыг өдөөх эрсдэлийг нэмэгдүүлсэн. Улмаар энэ нь манай улсын экспортын орлого буурах, инфляц өсөх, гадаад санхүүжилтийн өртөг, зардал нэмэгдэхэд шууд нөлөөлж болзошгүй байна. Иймд урт хугацаанд эдийн засгийг төрөлжүүлэх нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Түүнчлэн бизнесийн үйл ажиллагаа явуулах Зөвшөөрлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд нийт 16 зөвшөөрлөөр буюу боловсролын салбарт 4, байгаль орчны салбарт 3, банк, санхүүгийн салбарт 2, хүнс, хөдөө аж ахуйн салбарт 2, батлан хамгаалах салбарт 2, хууль зүйн салбарт 1, аймаг, нийслэлийн засаг даргаас олгох 2 зөвшөөрөл тус тус нэмэгдсэн байна. Зөвшөөрлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлд эрх бүхий этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих, энэ хуульд өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагыг тодорхойлох, зөвшөөрөл шинээр бий болгох, олгох үйл ажиллагаанд холбогдох санал, зөвлөмж гаргуулах чиг үүрэг бүхий төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөл Ерөнхий сайдын дэргэд ажилладаг бөгөөд уг зөвлөлөөс зөвшөөрөл олгох зарим эрх бүхий байгууллагууд энэ процессыг алгасаж хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зөрчлүүд гаргаж байна.

Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцаа хуульчлагдсан болон захиргааны хэм хэмжээний акт, журмаар зохицуулж байгаа байдлыг судалж үзэхэд, нийт 251 тусгай зөвшөөрлөөс 89 тусгай зөвшөөрөлд хамаарах харилцаа нь эрх бүхий байгууллагаас батлагдсан захиргааны хэм хэмжээний акт, журмаар, 33 зөвшөөрөлд хамаарах харилцаа нь хууль болон захиргааны хэм хэмжээний акт, журмаар давхардсан байдлаар зохицуулагдаж байгааг дурджээ. Өөрөөр хэлбэл нийт 251 төрлийн тусгай зөвшөөрлийн 122 зөвшөөрөлд хамаарах харилцааг захиргааны хэм хэмжээний акт, журмаар зохицуулж байна гэсэн судалгааны дүн гарсны дагуу Зөвшөөрлийн зөвлөлөөс Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, тус хуулийн зохицуулалтад салбарын хууль тогтоомж, журмуудыг нийцүүлэх чиглэлээр холбогдох дүгнэлт, зөвлөмжийг зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагуудад хүргүүлсний дагуу эрх бүхий байгууллагуудаас нийт 60 гаруй захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох, зарим зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг хэрэгжүүлсэн.

Хууль тогтоомжид зөвшөөрөл гэж нэрлэгдээгүй боловч бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд шаарддаг, төрийн байгууллагаас олгодог баримт бичгүүдийг Төрийн хэмнэлт, бүтээмжийн зөвлөлөөс судалж үзэхэд Монгол Улсын хуулиудад бүртгэл 264, дүгнэлт 232, гэрчилгээ 132, магадлан итгэмжлэл 30, сертификат 9 байна гэсэн үр дүн гарч, зөвшөөрөл олгох процесстой адилхан процессыг бүрдүүлж байгаа нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан “Хүн, хуулийн этгээд хуулиар хориглосон, эсхүл энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан тусгай болон энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээс бусад төрлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхэлж болно.” гэж заасантай зөрчил үүсгэж байна.

Зөвшөөрөл олголтын процессыг хөнгөвчлөх хүрээнд олон улсын байгууллагаас хийсэн судалгааны тайлан, гадаадын зарим улсын зөвшөөрлийн харилцааг зохицуулж буй хууль, эрх зүйн зохицуулалт, туршлагыг судалж үзэхэд тусгай болон энгийн зөвшөөрлөөс гадна зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагад мэдэгдэл хүргүүлэх замаар тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн зохицуулалт үйлчилж байна. Тухайлбал, Бүгд Найрамдах Казахстан Улсын Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд нэг удаагийн шинжтэй, эхлэх, дуусах хугацаатай, ахуйн хэрэгцээнд зориулан хийх эрсдэлийн түвшин багатай зөвшөөрлийн шинжтэй үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх нийтлэг харилцааг тусгасан байна. Тус хуульд “Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаа” гэж төрийн байгууллагаас баталсан мэдэгдлийн хуудасны дагуу тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх”-ийг хэлэх ба тухайн байгууллагын цахим мэдээллийн санд мэдэгдэх хуудсыг байршуулж, хяналт тавих, шаардлагатай тохиолдолд магадлан шалгах ажиллагааг зохион байгуулах, эрсдэлийн үнэлгээ хийдэг байхаар хуульчилжээ. Иргэн, хуулийн этгээд мэдэгдлийн хуудсанд заасан хугацаанд үйл

ажиллагаагаа эхлүүлж, дуусгавар болгох ба уг үйл ажиллагаатай холбоотой зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээдэг байна.

Олон улсад хэрэглэгдэж байгаа мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны талаарх зохицуулалтыг бий болгож зарим төрлийн тусгай болон энгийн зөвшөөрлийг мэдэгдэл хүргүүлсний үндсэн дээр эрхлэх, тусгай зөвшөөрлийн төрөл ангиллыг дахин тодорхойлох, нэр томъёог жигдлэн хуульчлах, тодорхой төрлийн зөвшөөрөл олгох процессын журмыг салбарын хуулиудад тусгаж оруулах, зөвшөөрөл эзэмшигчид тавих явцын хяналтыг сайжруулах замаар Зөвшөөрлийн тухай хуульд нийцээгүй захиргааны хэм хэмжээний акт, журмаар зөвшөөрлийн харилцааг зохицуулж, зөвшөөрөл олголтын процессыг хүндрүүлж байгаа нөхцөлийг арилгах, цахимжилтыг сайжруулах, хуульд заасан хугацаанд түргэн шуурхай, хүндрэл чирэгдэлгүй зөвшөөрөл авах нөхцөлийг бүрдүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүнд суртал, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх нөхцөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

Дээрх дурдсан асуудлуудыг шийдвэрлэх, Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт туссан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх, эдийн засагт нөлөөлж буй гадаад, дотоод хүчин зүйлсийг шийдвэрлэхийн тулд эдийн засгийг төрөлжүүлэх, бизнес эрхлэгчдийг дэмжсэн таатай орчныг бүрдүүлэх чухал болоод байна. Энэ хүрээнд аж ахуйн нэгжүүдийн зах зээлд нэвтрэхэд тулгардаг саад хоригийг арилгах, гарааны компаниудын бизнесийг дэмжих, экосистемийг бүрдүүлэх, зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжихэд чиглэсэн эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр бодлого, зохицуулалтын арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа нийт 933 (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд 2025.09.08-ны өдрийн байдлаар байршсан тоо) хуулиас аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрх (бизнес, хөрөнгө оруулалт, худалдаа г.м)-тэй шууд болон шууд бус холбоотой харилцааг зохицуулсан ойролцоогоор 360 гаруй хууль үйлчилж байна. Эдгээр хууль нь тухайн салбарын харилцааг нарийвчлан зохицуулсан байх ба ингэхдээ аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хязгаарласан, хориглосон, нэмэлт шаардлага тавьсан, зайлшгүй шаардлагатайгаас бусад байдлаар зөвшөөрөл авахыг шаардсан зэрэг зохицуулалтууд нэлээдгүй байна.

Иймд хуулиар хориглосноос бусад аж ахуйн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх, өмчийн халдашгүй байдлыг хангаж, аж ахуйн үйл ажиллагаанд оролцогчдын эрх тэгш байдлыг хангах, гадаад, дотоодын зах зээлд чөлөөтэй оролцох нөхцөлийг бүрдүүлэх, аж ахуйн үйл ажиллагаа дахь төрийн оролцоог багасгах шаардлагатай байна.

1.4. Бизнесийн эрх чөлөөг хангаж буй гадаад улсын хууль тогтоомжийн зохицуулалт

Олон улсын туршлагаас харахад бизнес эрхлэх эрх чөлөөг хуульд тусгаж, төрийн оролцоог хязгаарлах нь бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргалтад эерэг нөлөө үзүүлж, иргэд, олон нийт болон бизнес эрхлэгчдийн итгэлийг төрүүлж, төрийн бодлогын залгамж чанар, урьдчилан таамаглахуйц, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлдэг. Цаашлаад эдийн засаг, хөрөнгө оруулалтын өсөлтийг хангаж, тогтвортой байдлыг хадгалахад чухал нөлөөтэй гэж үзэж байна.

Манай улсын эдийн засгийн бүтэц, шилжилтийн үеийн эрх зүйн орчинтой тодорхой хэмжээгээр төстэй зарим орнуудад эдийн засаг, бизнесийн эрх чөлөөг хамгаалж, хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжих хүрээнд төрийн хэт оролцоо, хяналтыг бууруулж, баримт бичгийн шаардлагыг багасгаж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлээд байна. Тухайлбал, Бүгд Найрамдах Казахстан Улс, Гүрж Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс, Бүгд Найрамдах Киргиз Улс болон Бүгд Найрамдах Эстони Улсын холбогдох эрх зүйн зохицуулалтыг сонгон судалсан болно.

Гүрж Улс 2011 оны Эдийн засгийн эрх чөлөөний тухай (Organic Law of Georgia on Economic Freedom) хуулиар эдийн засгийн эрх, эрх чөлөөний ерөнхий баталгааг бий болгож, хуулийн оршил хэсэгт эдийн засгийн эрх, эрх чөлөө нь хүний үндсэн эрхийн нэг хэсэг бөгөөд зөвхөн Үндсэн хууль болон бусад хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд хязгаарлахыг хориглосон. Ингэхдээ эдийн засгийн эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхийн тулд төрийн оролцоог бага байлгах, хариуцлагатай макро эдийн засгийн бодлого хэрэгжүүлэх болон татварын хувь, хэмжээг бага байлгахад чиглэх талаар заасан. Мөн шинэ төрлийн татвар бий болгох, нэмэх зэрэг асуудалд иргэд, олон нийтийн оролцоог хангах, макро эдийн засгийн параметрийн хязгаарууд тухайлбал, төсвийн нийт зарлага ДНБ-ий 30%-аас хэтрэхгүй байх, төсвийн алдагдал ДНБ-ий 3%-аас ихгүй байх, улсын өр ДНБ-ий 60%-аас ихгүй байх зэргийг тогтоосон. 1996 онд батлагдсан Хөрөнгө оруулалтыг дэмжих, баталгаа олгох тухай (1996) хуулиар гадаад болон дотоодын хөрөнгө оруулалт, түүнийг хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн хууль бөгөөд тус хуулиар гадаадын хөрөнгө оруулагчийг үндэсний хөрөнгө оруулагчтай адил тэгш эрхтэй байхаар тогтоож, хөрөнгө, орлогоо чөлөөтэй гадагш шилжүүлэх, валют хөрвүүлэх, өмчийг эрхийг хамгаалсан зохицуулалттай. Мөн хөрөнгө оруулалтын нөхцөлийг дордуулсан хууль тогтоомжийг тодорхой хугацаанд буцаан хэрэглэхгүй байх тогтворжуулах баталгаа олгосон.

Казахстан Улсын Бизнес эрхлэгчийн тухай хууль (Entrepreneurial Code, 2015 онд батлагдсан)-ийн 10 дугаар зүйлд бизнес эрхлэгчийг харьяаллаар үл ялгаварлах зарчим болон тэгш эрхийн зарчмыг баталгаажуулж, 26 дугаар зүйлд хөрөнгө хураан авах тохиолдолд олгох нөхөн олговрыг “шударга, тэргүүн ээлжид” олгох, өмчлөгчийн эрхийг хамгаалсан. Мөн хууль тогтоомж тодорхой, тогтвортой байх талаар зааж, хуулийг буцаан хэрэглэхгүй байх, урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдал бий болгохоос сэргийлэх талаар заасан байна.

Киргиз Улсын Үндсэн хууль (2010 онд батлагдаж, 2021 онд нэмэлт орсон) болон Төрөөс бизнес эрхлэгчид үзүүлэх дэмжлэгийн тухай хууль (Law on State Support of Entrepreneurship)-д эдийн засгийн эрх чөлөө, бизнес эрхлэлтийг Үндсэн хуулиар хамгаалсан. Мөн бизнес эрхлэгчийн эрх зүйн байдлыг доордуулах тохиолдолд хуулийг буцаан хэрэглэхгүй байхыг тусгайлан заасан бөгөөд Төрөөс бизнес эрхлэгчид үзүүлэх дэмжлэгийн тухай хуулиар зах зээлд эрх тэгш нэвтрэх, хөрөнгө хамгаалах процессыг тусгасан.

Вьетнам Улсын Аж ахуйн нэгжийн хууль (Law on Enterprises, 2020)¹, Хөрөнгө оруулалтын тухай хууль (Law on Investment, 2020)² -д хориглосон болон нөхцөлтэй салбаруудаас бусад бизнесийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулагч чөлөөтэй оролцох зарчмыг хуульчилж, дотоод болон гадаадын хөрөнгө оруулагчдад хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд тэгш нөхцөлөөр зах зээлд нэвтрэх боломжийг олгосон. Түүнчлэн хууль тогтоомжийн өөрчлөлттэй холбогдуулан хөрөнгө

оруулалтын нөхцөл дордсон тохиолдолд өмнөх хуулийн хүрээнд эдэлж байсан хөрөнгө оруулалтын урамшууллыг хэвээр эдлэх, шинэ хууль тогтоомжоор хөрөнгө оруулалтын илүү таатай нөхцөл олгосон тохиолдолд тухайн шинэ хууль тогтоомжийн хүрээнд хөрөнгө оруулалтын урамшуулал хүртэх зэргийн талаар заасан байна.

Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ), Евразийн түншлэлийн харилцан үнэлгээний сайн туршлага (OECD-Euroasia Peer Practices)-д Евразийн Өрсөлдөх чадварын хөтөлбөрийн улс орнууд (Монгол Улс, Казакстан Улс, Киргиз Улс, Гүрж Улс, Украин Улс зэрэг) эдийн засгийн эрх чөлөөний зохицуулалтыг (өмчийн эрхийн хамгаалалтыг багтаан) батлах, мөн хууль буцаан хэрэглэхгүй байх, тэгш эрх, өрсөлдөөний тэгш байдал, хууль тогтоомж боловсруулах ажиллагаа нээлттэй, ил тод байх, түүнд оролцох боломжийг тусгахыг зөвлөсөн.

Манай улсын хувьд ч бүс нутгийн хэмжээнд өрсөлдөхүйц бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог бууруулж, төрийн байгууллага, албан тушаалтнуудын үйл ажиллагаа, шийдвэр гаргах түвшинд баримтлах суурь зарчмуудыг хуулиар баталгаажуулах нь зүйтэй байна.

Иймд дээр дурдсан нөхцөл байдал, судалгааны дүнг харгалзан Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын сайн туршлагад нийцүүлэн иргэн, хуулийн этгээдийн хуулиар хориглосноос бусад бизнесийн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх эрхийг баталгаажуулах, хувийн өмчийн халдашгүй байдлыг хангах, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах, зөвшөөрлийн процессыг цахимжуулж, хялбаршуулах, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх зорилгоор Бизнесийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсрууллаа.

Хоёр.Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл

Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг 2 бүлэг, 5 зүйл, 12 хэсэг, 12 заалттай байхаар боловсруулсан.

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд хуулийн зорилтыг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэн, хуулийн этгээдийн бизнесийн үйл ажиллагаа эрхлэх эрх, бизнесийн орчин дахь төрийн оролцооны хязгаарыг тогтоох, шударга өрсөлдөөнийг дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулахаар тусгасан. Тус зүйл нь бизнес эрхлэх эрх чөлөөг баталгаажуулах, бизнес эрхлэхэд төрийн оролцоог бууруулах, хууль тогтоомж, акт батлах замаар бизнесийн үйл ажиллагаанд хүндрэл, дарамт үзүүлдэг тогтолцоог өөрчлөх, бизнес эрхлэхтэй холбогдох төрийн байгууллага, албан тушаалтны аливаа шийдвэр, үйл ажиллагаанд мөрдлөг болгох суурь зарчмыг тогтоож, нэгдсэн ойлголт зарчмыг баримтлах, улмаар бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэхэд чиглэнэ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлд Бизнесийн эрх чөлөөний хууль тогтоомж түүнийг хэрэглэхтэй холбоотой зохицуулалтыг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжуудын нэгэн адилаар тусгасан.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлд бизнесийн эрх чөлөөг хангахтай холбоотойгоор төрөөс баримтлах зарчмуудыг баталгаажуулсан. Тухайлбал, хуулиар хориглосноос бусад бизнесийн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх, бизнесийн үйл ажиллагаанд хийх зохицуулалт нь ил тод, ойлгомжтой, урьдчилан таамаглах

боломжтой байх, бизнес эрхлэгчийг өмчийн хэлбэр, хөрөнгө оруулалтын эх үүсвэр, байршил, хэмжээ, салбар, хэлбэрээр ялгаварлахгүй хандах, төрийн үйлчилгээ цахим, нийтэд ил тод, бизнес эрхлэгчээс мэдээллийг нэг удаа авах зарчимд суурилсан байх гэх зэрэг болно.

Хоёрдугаар бүлэг. Бусад зүйл

Тус зүйлээр хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж, хууль зөрчсөн төрийн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр харин хууль зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан.

БИЗНЕСИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ДАГАЛДУУЛАН БОЛОВСРУУЛСАН ХУУЛИЙН ТӨСЛҮҮД

Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон бусад холбогдох бусад хуулийн төслийг боловсруулсан.

Нэг. Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр дараах агуулга бүхий зүйл, хэсэг, заалт нэмлээ.

1/Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1.13, 3.1.14, 3.1.15 дахь заалтуудаар “хөрөнгө оруулагчийн гомдол, хөрөнгө оруулалтын маргаан, үндэсний таатай нөхцөл” гэх ойлголтуудыг анх удаа тодорхойлж тусгалаа. Ингэснээр хөрөнгө оруулалтын гомдол болон хөрөнгө оруулалтын маргаан хоорондын зааг ялгааг тодорхойлж, хөрөнгө оруулалтын гомдол, маргаантай холбоотой харилцааг зохицуулах бусад хууль, зүйл, заалтыг хэрэглээг боловсронгуй болгох ач холбогдолтой юм. Мөн үндэсний таатай нөхцөл гэж олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүй дэх ойлголтыг хуулиар баталгаажуулж, тус нөхцөлийг санал болгох замаар хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хөрөнгө оруулалтыг татахад ач холбогдолтой.

2/Хуулийн төслийн 4¹ дүгээр зүйлээр хөрөнгө оруулалтын талаар баримтлах зарчмыг нэмж тусгалаа. Ингэхдээ Хөрөнгө оруулалтын тухай хуулийг хэрэгжүүлэхэд төрөөс Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан зарчмаас гадна дараах үндсэн зарчмыг баримтална гэж тодорхойлсон бөгөөд дараах зарчмууд багтана. Үүнд:

- хөрөнгө оруулагчид шударга, тэгш хандах;
- хөрөнгө оруулагчийг үл ялгаварлан гадуурхах;
- хөрөнгө оруулалтыг хамгаалах, хөрөнгө оруулалтын үр шим, хууль ёсоор олсон орлого, хөрөнгөө чөлөөтэй эзэмших, ашиглах, захиран зарцуулах;
- хөрөнгө оруулалтын орчны ил тод, тогтвортой, урьдчилан таамаглахуйц байдлыг хангах;
- гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх;
- тогтвортой, хариуцлагатай хөрөнгө оруулалтыг дэмжих.

Ийнхүү хөрөнгө оруулалтын талаар төрөөс баримтлах зарчмыг тодорхойлсон нь энэхүү хуулийг олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйн зарчимд нийцүүлэх замаар гадаадын болоод дотоодын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, төрийн бодлого, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, залгамж чанарыг нэмэгдүүлэх зэрэг ач холбогдолтой зохицуулалт юм.

3/Хуулийн төслийн 5.1.6, 5.1.7 дахь заалтыг нэмэх замаар Монгол Улсад хөрөнгө оруулалт хийх хэлбэрийг өргөжүүлэв. Ийнхүү өөрчлөлтийг оруулснаар дараах салбарт хөрөнгө оруулах боломжтой болов. Үүнд:

- үйлдвэр, машин механизм, технологи дамжуулах, барилга байгууламжийн үндсэн хөрөнгөд биет байдлаар хөрөнгө оруулалт хийх;
- оюуны өмчийн эрхийг холбогдох хуульд заасны дагуу эдийн засгийн эргэлтэд оруулахад хөрөнгө оруулалт хийх;

- Хуулийн төслийн 6 дугаар зүйл буюу хөрөнгө оруулалтын эрх зүйн нийтлэг баталгаанд 6.11-6.14 дэх хэсэгт дараах агуулга бүхий зохицуулалтыг нэмж тусгасан бөгөөд тус зохицуулалтууд нь хөрөнгө оруулагчдад үзүүлэх төрийн баталгааг нэмэгдүүлэхэд чиглэсэн болно. Үүнд:
 - 6.11.Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 27, 62.1-д зааснаар хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа шийдвэрийн талаар урьдчилан мэдээлж, олон нийтийн оролцоог хангаж хэлэлцүүлэх, албан ёсоор хэвлэн нийтэлж нээлттэй болгоно.
 - 6.12.Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн бол түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, учирсан хохирлыг хуульд заасны дагуу барагдуулна.
 - 6.13.Хууль бус үндэслэлээр хөрөнгө оруулагчийн үйл ажиллагааг аливаа хэлбэрээр зогсоох, түдгэлзүүлэх, саад учруулахыг хориглоно.
 - 6.14.Хуульд зааснаас бусад тохиолдолд хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын тоо жилд хоёроос ихгүй байна.

4/Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Хөрөнгө оруулалтын тухай хуулиар зөвхөн хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийг тусгасан. Засгийн газраас хөрөнгө оруулалт татна, хөрөнгө оруулагчаа дэмжих чиглэлээр ямар эрх үүрэгтэй оролцох нь гол хуульдаа тусгаагүй байна.

Тухайлбал, хувийн хэвшил, шууд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх боломжтой хөгжлийн төсөлд хөрөнгө оруулагчдад нээлттэй санал тавих, хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах талаар эрх зүйн зохицуулалт алга байна. Мөн хөрөнгө оруулалттай холбоотой бодлогын шийдвэр гаргах, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр орон нутаг, бусад байгууллагад үүрэг чиглэл өгөх эрхийг нэмэлт оруулсан.

Хуулийн төслийн 8¹ дүгээр зүйлээр Засгийн газрын бүрэн эрхийг, 9¹ дүгээр зүйлээр Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрх, үүргийг тус тус тодорхойлсон.

Мөн хуулийн 9.2 дахь хэсэг буюу Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүрэгт хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах асуудлаар Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх гэх агуулга бүхий заалтыг нэмсэн.

5/Хуулийн 7 дугаар бүлэгт “Хөрөнгө оруулагчийн гомдол, маргааныг шийдвэрлэх” зохицуулалтыг шинээр тусгасан. Энэхүү бүлгээр хөрөнгө оруулагчийг гомдлыг хүлээн авах хүрээ, түүнийг шийдвэрлэх субъект, хугацаа болон хөрөнгө оруулалтын маргаантай холбоотой заалтуудыг нэмсэн.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлээр Хөрөнгө оруулалтын тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтад үг, өгүүлбэр нэмэн зохицуулалтыг боловсронгуй болгов.

1/Хөрөнгө оруулагчийн хөрөнгийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хууль бусаар хураан авахыг хориглохоор зохицуулсныг “шууд болон шууд бусаар хураан

авах"-ыг хориглохоор илүү нарийвчлан зохицуулав. Хөрөнгө оруулагчийн өмчийн эрхийг хамгаалах, хөрөнгийг хураан авах, ийнхүү хураан авах тохиолдолд нөхөн олговор олгохтой холбоотой харилцааг хөрөнгө оруулалтыг хамгаалах хоёр талт хэлэлцээрүүд, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Хөрөнгө оруулалтын тухай хууль, нөхөн төлбөр олгохтой холбоотой харилцааг Иргэний хууль, Захиргааны ерөнхий хуулиар зохицуулж байна. Эдгээр хууль тогтоомж хөрөнгийг зөвхөн шууд хууль ёсны дагуу хураан авах, энэ тохиолдолд нөхөн олговор олгохтой холбоотой зохицуулалт бөгөөд хөрөнгийг шууд бусаар хураан авахыг хуульчилсан, тодорхойлсон зүйл байхгүй байна. Шууд болон шууд бусаар гэж ангилсан ганц хэлэлцээр бол Канад-Монгол улсын хөрөнгө оруулалтын хэлэлцээр юм. Тус хэлэлцээрийн 10-р зүйлд заалтад шууд бусаар хураан авах үйлдлийг "шууд хураан авахтай ижил төстэй арга хэмжээ" гэж тодорхойлсон байдаг³. Хөрөнгө оруулалтын эрх зүйд хөрөнгийг шууд бусаар хураан авах тухай ойлголт түгээмэл байгаа бөгөөд энэ нь эд хөрөнгийн өмчлөх эрх шилжихгүй ч хөрөнгө оруулагч хөрөнгөө удирдах, ашиглах, захиран зарцуулах боломжгүй нөхцөл үүсэхийг ойлгоно. Тодруулбал, төрөөс зөвшөөрөл өгөхөөс татгалзах, зөвшөөрлийг цуцлах, захиргааны хэм хэмжээний актаар бизнесийн үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох, дэмжлэг үзүүлэхгүй байх, байгаль орчны, эрүүл мэндийн хязгаарлалт, хориг, шүүхийн шийдвэрээр хураан авах гэх мэтээр багтаж болдог⁴. Дээр дурдсанчлан Дэлхийн өв уламжлалын сангаас "Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс"-ийн өмчийн эрхийн шалгуур үзүүлэлтээр монгол улс 184 орноос "өмчийн эрх"-ийн үзүүлэлтээр 92-т эрэмбэлэгдэж "хаалттай" гэж үнэлэгдсэн тул энэхүү зохицуулалт нь хөрөнгө оруулагчийн өмчийн эрхийг хамгаалах баталгаа болсон чухал ач холбогдол бүхий зохицуулалт юм.

2/Түүнчлэн Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 6.5 дахь хэсэгт хуульд зааснаар дайчлан авсан хөрөнгийн нөхөн олговрыг тооцохдоо тухайн хөрөнгийг дайчлан авсан үеийн буюу энэ тухай хөрөнгө оруулагчид, эсхүл нийтэд мэдэгдэх үеийн зах зээлийн үнэлгээгээр гэснийг "олон улсын зах зээлийн үнэлгээгээр" гэж тодотгон хууль хэрэглээний хувьд илүү ойлгомжтой болгосон. Мөн тус зүйлд "Тус нөхөн олговор нь бүрэн хөрвөх, чөлөөтэй шилжүүлж болохуйц байна." гэж нэмсэн.

3/Хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг хэсэг буюу хуулийн 7.1.8 дахь заалтаар "гомдол гаргах эрх"-ийг баталгаажуулав.

4/Гадаадын төрийн өмчит хуулийн этгээд нь уул уурхай, банк санхүү, хэвлэл, мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс хувийг эзэмших тохиолдолд зөвшөөрөл авахаар Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлд тусгасан. Үүнийг хуулийн этгээдийн хувь эзэмшлийг **шууд болон шууд бусаар** хэмээн тодотгосон.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлээр Хөрөнгө оруулалтын тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг өөрчлөн найруулав.

Тогтворжуулах гэрчилгээг олгох шалгуур үзүүлэлтийг багасгаж, хугацааг уртасган, гэрчилгээ олгох бүс нутгийг Улаанбаатарын, Хангайн, Зүүн, Баруун гэж 5 ангилж байсныг Улаанбаатар хот болон бусад гэж ангилав.

³ Алтангэрэл Т. Хөрөнгө оруулалтыг шууд болон шууд бусаар хураан авахад үүсэх нөхөн төлбөрийн эрх зүйн зохицуулалт <https://legaldata.mn/b/1830> Хамгийн сүүлд 2026 оны 05 дугаар сарын 29 өдөр хандсан.

⁴ Мөн тэнд

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлээр хуулийн зарим үг, өгүүлбэр, нэр томьёо дугаарлалт зэргийг өөрчлөв.

Тухайлбал, хуулийн 3.1.5-д “аж ахуйн нэгж” гэснийг “хуулийн этгээд” гэж, хуульд оруулж буй зарим нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан бүлгийн нэр, хэсэг, зүйл, заалтын дугаарыг өөрчилсөн болно.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлээр хуулийн зарим үг, өгүүлбэрийг хасах замаар өөрчлөв.

Тухайлбал, Хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “салбар” гэснийг, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “энэ хуулийн 9.3-т заасан зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн” гэсэн хэсгийг тус тус хасахаар боловсруулав.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлээр хүчингүй болж буй зүйл, хэсэг, заалтыг боловсруулав.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн 9 дүгээр зүйлд Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүргийг тусгасан бөгөөд яамны зарим чиг үүргийг хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад шилжүүлж байгаатай холбогдуулан 9.1, 9.2.4-9.2.9 дэх заалт, 9.2.14 заалтыг тус тус хүчингүй болгов. Тогтворжуулах гэрчилгээг олгох хугацаа, шалгуур үзүүлэлтийг бууруулсан зэрэг өөрчлөлттэй холбогдуулан 16 дугаар зүйлийн 16.4, 16.5 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.2.5 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.1.8 дахь заалтыг тус тус хүчингүй болгов.

Хоёр. Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах чиглэлээр боловсруулсан бусад дагалдах хуулийн төсөл

Аж ахуйн нэгжийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын хэлбэрээр ялгаварласан, үйл ажиллагаа явуулахыг хориглосон, хязгаарласан зохицуулалт болон төрийн үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлага, хүсэлтээ шийдвэрлүүлэх хугацаа, төлбөр хураамжийг ялгамжтай тогтоосноос шалтгаалан гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд хараат болон охин компани, компанийн нэгдлийг байгуулж байгаа нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын бодит үр өгөөжийг тодорхойлох, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлоход хүндрэл үүсгэсээр байна. Мөн Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж, үйл ажиллагаа явуулах боломжийг хязгаарлаж, хориглосон, эсхүл гадаадын иргэн, хуулийн этгээдэд нэмэлт шаардлага тавьсан хуулиуд байх бөгөөд эдгээрээс зүй ёсны буюу байх ёстой шаардлагыг тогтоосон хуулиудаас гадна гадаадын иргэн, хуулийн этгээдийг Монгол Улсад аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, хөрөнгө оруулах боломжийг хязгаарласан, хориглолт тогтоосон, ач холбогдолгүй нэмэлт шаардлагыг бий болгосон хэд хэдэн хууль хүчин төгөлдөр үйлчилж байна. Иймд Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд бусад холбогдох хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.

2.1.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Оюуны өмчийн тухай хууль, Хөдөө, аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль зэрэг салбар хуулиудад тусгасан гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийг хязгаарласан заалтуудыг хасаж, заримыг хүчингүй болгов. Ингэснээр гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд дотоодын хүчин чадлаар гүйцэтгэхэд хүндрэлтэй эсхүл мэргэжлийн ур чадвар шаардагдах салбаруудад үйл ажиллагаа явуулах, цаашлаад томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм.

2.2.Зарим хууль тогтоомжоор гадаадын болон дотоодын хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх хугацаа, хураамж зэргийг ялгамжтай байхаар зохицуулсныг арилгаж, зарим хугацааг бууруулах зэргээр тэгш эрхийг олгов. Тухайлбал,

- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг бүртгэх эсэх талаар шийдвэрийг ажлын 10 өдөр гаргадаг байсныг “ажлын 5” өдөр гэж бууруулав.
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхэд 750 000 төгрөг тооцдог байсныг “350 000” болгон бууруулж, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд болон гадаадын хуулийн этгээдийн салбар төлөөлөгчийн газрын баримт бичигт өөрчлөлт оруулахад төлөх хураамжийн тус тус “10,000” төгрөг болгон дотоодын аж ахуйн нэгжтэй ижил байхаар зохицуулав.

2.3.Хөрөнгө оруулалтын талаарх төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлж, зарим чиг үүргийн давхардлыг арилгах, хүртээмжийг нэмэгдүүлж шаардлагатайгаас бусад тохиолдолд цахим, сүлжээг ашиглах үйл ажиллагаандаа нэвтрүүлэх хүрээнд Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Дипломат албаны тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд тус тус өөрчлөлт оруулахаар боловсруулав

2.4.Хөрөнгө оруулагчдад татварын ээлтэй орчин бүрдүүлэх хүрээнд Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд тус тус өөрчлөлт оруулахаар боловсруулав.

Гурав. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төсөл

Зөвшөөрлийн тухай хуульд заасан зөвшөөрөлтэй холбогдох зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлангаар тусгай зөвшөөрлийн төрөл ангиллыг дахин тодорхойлох, нэр томьёог жигдлэн хуульчлах, тодорхой төрлийн тусгай зөвшөөрөл олгох процессын журмыг салбарын хуулиудад тусгаж оруулах, тусгай зөвшөөрлүүдийг бүрэн цахимжуулах талаар дараах 13 салбарт чиглсэн дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хуулийн төсөлд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг орууллаа.

1. Байгаль орчны чиглэл
2. Банк, банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний чиглэл
3. Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэл
4. Зам, тээврийн чиглэл
5. Санхүү, эдийн засаг, гааль, хөрөнгө оруулалтын чиглэл
6. Соёл, боловсролын чиглэл
7. Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн чиглэл
8. Харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэл
9. Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааны чиглэл
10. Хууль зүйн болон нийтлэг бусад асуудлаар
11. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэл
12. Эрүүл мэндийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагаа
13. Эрчим хүчний чиглэлээр доор дурдсан үйл ажиллагаа

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр дараах агуулга бүхий зүйл, хэсэг, заалт нэмлээ.

Зөвшөөрлийн тогтолцоог цахим хэлбэрт шилжүүлэх, эрсдэл багатай зарим үйл ажиллагааг зөвшөөрөл авах бус мэдэгдлийн үндсэн дээр эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, зөвшөөрөл олгох, сунгах ажиллагааг хялбаршуулах, бизнес эрхлэгчид тавигдах зарим давхардсан болон хүндрэлтэй шаардлагыг бууруулах чиглэлээр зохицуулалт тусгагдсан.

Түүнчлэн “мэдэгдэл” болон “мэдэгдэл хүлээн авах эрх бүхий этгээд” гэсэн ойлголтыг хуулийн 1.4, 1.5 дахь хэсэгт шинээр тодорхойлж, мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх нийтлэг журмыг хуульд зохицуулахаар байна. Ингэснээр эрсдэлийн үнэлгээгээр эрсдэл багатай гэж тогтоогдсон, эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр эрхлэх боломжтой үйл ажиллагааг зөвшөөрөл шаардахгүйгээр бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд цахимаар мэдэгдэл хүргүүлсний үндсэн дээр эрхлэх боломж бүрдэх юм. Мэдэгдэл хүргүүлсэн этгээдийг тухайн үйл ажиллагааг эрхлэх бүртгэлтэй этгээдэд тооцох бөгөөд эрх бүхий байгууллагаас уг мэдэгдлийг зөвшөөрөх, эсхүл татгалзах шийдвэр гаргахгүй байхаар зохицуулсан.

Мөн зөвшөөрөл болон мэдэгдлийн баримт бичгийн хэлбэр, эрх зүйн хүчин чадлыг тодорхой болгожээ. Зөвшөөрөл олгосныг тодорхойлох гэрчилгээ, түүнтэй адилтгах эрхийн бичгийг цахим хэлбэрээр олгох бөгөөд уг цахим баримт бичиг нь зөвшөөрөл олгосон шийдвэр болон зөвшөөрлийн лавлагаатай адил эрх зүйн хүчинтэй байхаар тусгасан байна. Түүнчлэн зөвшөөрлийн баримт бичгийг гээх, үрэгдүүлэх, гэмтээх, хүлээн аваагүй байх нь зөвшөөрлийг хүчингүй гэж үзэх үндэслэл болохгүй байхаар зохицуулснаар цаасан баримт бичгээс хамаарах хамаарлыг бууруулж, цахим бүртгэл, лавлагааны хэрэглээг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Хуулийн төсөлд мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх этгээдийн эрх, үүргийг тодорхой тусгасан. Тухайн этгээд үйл ажиллагаагаа эхлүүлэхээс ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө зөвшөөрөл, мэдэгдлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд цахим хэлбэрээр мэдэгдлээ бүртгүүлснээр мэдэгдлийг эрх бүхий байгууллагад хүргүүлсэнд тооцохоор тусгасан.

Мэдэгдэл хүлээн авах эрх бүхий байгууллага нь мэдэгдлийг зөвшөөрөл, мэдэгдлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаас хүлээн авч, холбогдох бусад мэдээллийг нийтийн мэдээллийн дэд бүтцээр дамжуулан солилцох, баримт бичгийн бүрдлийг хянан үзэх, нөхөн бүрдүүлэх шаардлагатай баримт бичгийн талаар мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх этгээдэд мэдэгдэх эрх, үүрэгтэй байхаар зохицуулсан бөгөөд харин мэдэгдэл хүргүүлэхгүйгээр үйл ажиллагаа эрхэлсэн, эсхүл баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдсон тохиолдолд үйл ажиллагааг зогсоох зохицуулалт оруулсан.

Хуулийн төсөлд энгийн зөвшөөрлийн жагсаалтад байгаль орчин, санхүү, газар, зам тээвэр, гааль, нийгмийн үйлчилгээ, ашигт малтмал, хууль зүй, архив, онцгой байдал, хүнс, хөдөө аж ахуйн чиглэлийн зарим үйл ажиллагааг шинээр нэмж, тэдгээрийг олгох эрх бүхий байгууллага, албан тушаалтныг тодорхойлсон. Тухайлбал, химийн хорт болон аюултай бодис импортлох, ашиглах, ойгоос мод бэлтгэх, үл хөдлөх эд хөрөнгө зуучлал, үнэт металл, үнэт чулууны арилжаа, даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа, газар зохион байгуулалт, газрын кадастр, тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх, орон нутгийн зорчигч тээвэр, аудит, хөрөнгийн үнэлгээ, гаалийн баталгаат бүс, агуулах, татваргүй барааны дэлгүүр, хүүхэд харах үйлчилгээ, шатахууны худалдаа, түгээмэл тархацтай ашигт малтмал

хайх, ашиглах, архивын баримт хадгалах, хуульч, өмгөөлөгч, оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, гамшгийн эрсдэлийн үнэлгээ, согтууруулах ундаа худалдах, ургамал хамгааллын бүтээгдэхүүн импортлох, худалдаалах зэрэг үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээр заасан.

Мөн хуулийн төсөлд мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны жагсаалтыг шинээр нэмж, эрсдэл багатай зарим үйл ажиллагааг зөвшөөрөл авахгүйгээр эрх бүхий байгууллагад мэдэгдсэний үндсэн дээр эрхлэх зохицуулалтыг тусгалаа. Үүнд 100 килограмм хүртэл химийн хорт болон аюултай бодис импортлох, ашиглах, банк бус санхүүгийн байгууллага болон даатгалын байгууллагын нэр, байршил өөрчлөх, мөнгөн зээлийн үйл ажиллагааны салбар бүртгүүлэх, такси үйлчилгээ эрхлэх, татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ, гадаадын иргэн, хуулийн этгээдийн кино зураг авалт хийх, мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх, эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах зэрэг үйл ажиллагаа хамрагдаж байна.

Түүнчлэн зөвшөөрөл хүсэгч, зөвшөөрөл эзэмшигчид тавигдах зарим шаардлагыг хязгаарласан болно. Тухайлбал, зөвшөөрөлд тавигдах шаардлагад хамаарах газар, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмжийг заавал зөвшөөрөл хүсэгч, эсхүл эзэмшигчийн өмчлөл, эзэмшилд байхыг шаардахгүй байхаар тусгажээ. Мөн зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох ажиллагаанд татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй байх шаардлага тавихгүй байхаар зохицуулсан нь бизнес эрхлэгчид учирдаг захиргааны болон санхүүгийн дарамтыг бууруулахад чиглэсэн ач холбогдолтой.

Зөвшөөрлийн хугацаатай холбоотойгоор нэг удаагийн шинжтэй, эсхүл улирлын чанартай үйл ажиллагаанд зөвшөөрлийн хугацааны ерөнхий зохицуулалт хамаарахгүй байхаар нэмэлт оруулж, тухайн үйл ажиллагааны онцлог, хэрэгжих хугацаанд нийцүүлэн уян хатан зохицуулалт хэрэглэх боломжийг бүрдүүлснээр давуу талтай юм.

Тус зүйлд зөвшөөрөл сунгах ажиллагааг хялбаршуулахтай холбоотой зөвшөөрөл сунгуулах хүсэлт гаргасан этгээд нь зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнөх нэг жилийн хугацаанд зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчөөгүй болох нь хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд зөвшөөрлийг магадлан шалгах ажиллагаа хийхгүйгээр сунгахаар байна. Эрх бүхий этгээд уг дүгнэлтийг үндэслэн зөвшөөрөл сунгуулах хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын хоёр өдрийн дотор шийдвэрлэхээр тусгасан нь хууль сахин ажилласан этгээдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Эрх бүхий этгээдийн зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагаанд Засгийн газар дахь хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авахаар тусгасан байна. Энэ нь зөвшөөрлийн чиг үүрэг хэрэгжүүлж буй байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт, уялдаа холбоог сайжруулах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилготой юм.

Хуулийн төслийн нэг дүгээр зүйл нь зөвшөөрлийн харилцааг цахимжуулах, зөвшөөрөл шаардах үйл ажиллагааны хүрээг оновчтой болгох, эрсдэл багатай үйл ажиллагаанд мэдэгдлийн горим нэвтрүүлэх, зөвшөөрлийн сунгалтыг хялбаршуулах, төрийн байгууллагын хяналт, мэдээлэл солилцоог сайжруулах замаар иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлээр Зөвшөөрлийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтад үг, өгүүлбэр нэмэн зохицуулалтыг боловсронгуй болгов.

Зөвшөөрлийн тухай хуульд оруулах нэмэлтээр хуулийн үйлчлэх эрх зүйн үндэслэлд Захиргааны ерөнхий хуулийг нэмж тусгаж, зөвшөөрлийн харилцааг захиргааны шийдвэр, ажиллагааны нийтлэг зарчимтай уялдуулж, Хоёрдугаар бүлгийн гарчигт “мэдэгдэл” гэсэн зохицуулалтыг нэмж, зөвшөөрлөөс гадна мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндсийг хуульд тусгасан.

Түүнчлэн тусгай зөвшөөрөл эзэмшигч, эрх бүхий этгээдтэй холбоотой зарим заалтад агуулгад нэмэлт оруулж, авто үйлчилгээний чиглэлд “зөөж тээвэрлэх” үйл ажиллагааг хамруулж зохицуулсан байна.

Мөн зүйлд Зөвшөөрлийн зөвлөлийн бүрэлдэхүүний 50-иас доошгүй хувийг мэргэжлийн нэгдсэн холбоо, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдүүлэхээр тусгаж, зөвшөөрлийн бодлого, шийдвэр гаргах ажиллагаанд мэргэжлийн болон иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн зохицуулалт оруулсан.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлээр Зөвшөөрлийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг өөрчлөн найруулав.

зөвшөөрөл болон мэдэгдлийн харилцааны хамрах хүрээг шинэчилж, хуулиар хориглосон, эсхүл тусгай, энгийн зөвшөөрөл болон мэдэгдлээр эрхлэхээр зааснаас бусад үйл ажиллагааг иргэн, хуулийн этгээд чөлөөтэй эрхлэх зарчмыг баталгаажуулсан. Мөн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн ойлголтыг зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох бүрэн эрхтэй этгээд байхаар өргөжүүлсэн.

Хуулийн төсөлд зөвшөөрөл, мэдэгдлийн ангиллыг эрсдэлийн үнэлгээнд суурилуулах зохицуулалтыг нарийвчилж, өндөр эрсдэлтэй үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлд, дунд эрсдэлтэй үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлд хамааруулахаар тусгасан. Зөвшөөрөл, мэдэгдлийг шинээр бий болгох, ангилал хооронд шилжүүлэх, өөрчлөх тохиолдолд тухайн үйл ажиллагааны нийгэм, эдийн засгийн үр ашиг, хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх нөлөөлөлд судалгаа, шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ хийхээр зохицуулсан.

Зөвшөөрөл, мэдэгдлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг цахим хэлбэртэй байхаар өөрчлөн найруулж, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэрийн мэдээлэл болон мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны мэдээллийг уг санд төвлөрүүлж, зөвшөөрөл, мэдэгдлийн мэдээллийн ил тод байдал, хяналт, цахим үйлчилгээний нэгдмэл байдлыг хангах нөхцөл бүрдүүлсэн.

Байгаль орчин, төмөр замын тээвэр, нийтийн зорчигч тээвэр, боловсролын магадлан итгэмжлэл, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ зэрэг чиглэлийн зарим тусгай зөвшөөрлийн нэр төрөл, олгох эрх бүхий этгээдийг шинэчлэн найруулсан. Түүнчлэн санхүүгийн зах зээлийн хүрээнд хувьцааны хамтын санхүүжилт, актуарчийн үйл ажиллагаа, мөн ан агнах болон спорт-сургалтын зориулалттай галт зэвсэг, түүнтэй адилтгах хэрэгслийг хилээр оруулах, гаргах, худалдан авах үйл ажиллагааг энгийн зөвшөөрлийн жагсаалтад хамруулсан.

Зөвшөөрлийн зөвлөл зөвшөөрөл, мэдэгдлийн эрсдэлийн үнэлгээг хоёр жил тутам хийж, шинээр бий болгох, хэвээр үлдээх, ангилал өөрчлөх, жагсаалтаас хасах асуудлаар дүгнэлт гарган Засгийн газарт танилцуулах зохицуулалт нэмэгдсэн байна. Үнэлгээ хийх ажиллагаанд мэргэжлийн нэгдсэн холбоо, төрийн бус байгууллагын оролцоог хангахаар тусгасан нь зөвшөөрлийн тогтолцоог эрсдэлд суурилсан, ил тод, оролцоотой болгох зохицуулалт хийсэн.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлээр хуулийн зарим үг, өгүүлбэр, нэр томьёо дугаарлалт зэргийг өөрчлөв.

хуулийн нэр, зорилго, бүлэг, зүйл, хэсгийн нэр томьёог “зөвшөөрөл, мэдэгдэл” гэсэн агуулгад нийцүүлэн өөрчлөхөөр тусгасан байна. Ингэснээр хууль нь зөвхөн зөвшөөрлийн харилцааг бус, мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны журам, жагсаалт, бүртгэлийн харилцааг хамарсан зохицуулалттай болж байна.

Мөн зөвшөөрлийн хугацаатай холбоотой зохицуулалтыг өөрчилж, тусгай зөвшөөрлийн хугацааг таван жилээс арван жил, энгийн зөвшөөрлийн хугацааг гурван жилээс таван жил болгон сунгахаар тусгажээ. Түүнчлэн байгаль орчин, боловсрол, эрүүл мэнд, эрчим хүч, шуудан, газрын тос, санхүү, тээвэр зэрэг салбарын зарим зөвшөөрлийн нэршил, хамрах хүрээ болон зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагыг шинэчлэн тодорхойлсон байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлээр хуулийн зарим үг, өгүүлбэрийг хасах замаар өөрчлөв.

Зөвшөөрлийн тухай хуулийн зарим заалтаас давхардсан, шинээр оруулсан зохицуулалттай нийцүүлсэн нэр томьёо, нөхцөлийг хасахаар тусгасан. Тухайлбал, төрийн зарим чиг үүргийг шилжүүлэхтэй холбоотой “гэрээнд” гэсэн зохицуулалт, зөвшөөрлийн ангилалтай холбоотой зарим давхардал, мөн зөвшөөрөл сунгахад татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй байх гэсэн шаардлагыг хасахаар тусгасан.

Эдгээр өөрчлөлт нь зөвшөөрөл олгох, сунгах ажиллагаанд тавигдах нэмэлт шаардлагыг багасгах, хуулийн нэр томьёо, зохицуулалтыг мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаатай нийцүүлэх, иргэн, хуулийн этгээдэд учруулах захиргааны дарамтыг бууруулахад чиглэсэн.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлээр хүчингүй болж буй зүйл, хэсэг, заалтыг боловсруулав.

Зөвшөөрлийн тухай хуулийн тусгай болон энгийн зөвшөөрлийн жагсаалтад байгаа холбогдох заалтыг хүчингүй болсонд тооцохоор тусгасан бөгөөд зөвшөөрлийн жагсаалтыг уялдуулах, давхардсан болон шаардлагагүй зөвшөөрлийг бууруулах, зарим үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх, улмаар зөвшөөрлийн тогтолцоог эрсдэлд суурилсан, илүү оновчтой хэлбэрт шилжүүлэх зорилтуудтай нийцүүлсэн.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөд туссан өөрчлөлтүүд нь зөвшөөрлийн тогтолцоог эрсдэлд суурилсан, ил тод, цахим, хялбаршуулсан хэлбэрт шилжүүлэхэд чиглэсэн болно. Тухайлбал, бага эрсдэлтэй, нэг удаагийн шинжтэй, тодорхой хугацаанд хэрэгжих, эсхүл ахуйн хэрэгцээний зориулалттай зарим үйл ажиллагааг зөвшөөрөл авах бус мэдэгдлийн үндсэн дээр эрхлэх боломжийг бүрдүүлж, мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны жагсаалт, хугацаа, журам, хяналт, мэдэгдэл хүлээн авах байгууллагын бүрэн эрх, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгоно.

Захиргааны байгууллагаас зөвшөөрөл, мэдэгдлийг үндэслэлгүйгээр нэмэх, задлах, хуваах, салгах, хамрах хүрээг өргөжүүлэхийг хориглож, салбарын хуулиудад туссан зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой давхардсан, зөрүүтэй зохицуулалтыг цэгцэлж, практик шаардлагад нийцүүлэн зарим зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийг өөрчлөх, зарим эрхийг мэргэжлийн холбоодод шилжүүлэх, зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа

доголдолгүй бол явцын хяналтын үр дүнд үндэслэн шууд сунгах зохицуулалтыг тусгасан.

Хуулийн төсөл батлагдсанаар бизнес эрхлэх орчин сайжирч, зөвшөөрөлтэй холбоотой хүнд суртал, авлига, албан тушаалтнаас хамаарах байдлыг бууруулах нөхцөл бүрдэх бөгөөд төрийн оролцоо багасаж, хувийн хэвшлийн санаачилга, зах зээлийн өрсөлдөөн, хөрөнгө оруулалт нэмэгдэхийн зэрэгцээ зөвшөөрөл олгох, сунгах ажиллагаанд шаардагдах баримт бичиг, шат дамжлага багасаж, зөвшөөрлийн үйл ажиллагааг цахимжуулснаар төрийн үйлчилгээ илүү шуурхай, ил тод болж, олон нийтийн оролцоо, хяналт нэмэгдэх ач холбогдолтой юм.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт өөрчлөлттэй уялдуулан салбарын 83 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан болно.

--oOo--